ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад сумын 23 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/123/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өмнөговь аймаг<br>2023 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539  Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас:99014247  Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК<br>Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46080
Утас: (976) 7053 3538, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.17 № 45

танай ______ -ны № ______ -т


ДАЛАНЗАДГАД СУМЫН 23-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.НАЙДАЛМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 23 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын 23 дугаар цэцэрлэгийн 2022оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

"Нэмэлт хоол" хөтөлбөрийн хүрээнд витаминтай хоолны хэрэгцээ шаардлагатай 50 хүүхдийг хамруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2022 оны 91 дугээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020064

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсах материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсаж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

(сая төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|
| Санхүүгийн байдлын тайлан | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 9.8 | 10.4 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,198.0 | 1,323.6 |
| Нийт хөрөнгийн дүн | 1,296.4 | 1,428.1 |
| Нийт өр төлбөрийн дүн | 0.0 | 0.4 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,296.4 | 1,427.7 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,296.4 | 1,428.1 |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан | | |
| Үйл ажиллагааны орлогын дүн | 396.7 | 611.4 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 437.5 | 477.9 |
| Үйл ажиллагааны үр дүн | (40.7) | 133.4 |
| Үйл ажиллагааны бус үр дүн | - | 2.7 |
| Үйл ажиллагааны нийт үр дүн | (40.7) | 130.8 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | | |
| Засгийн газрын оруулсан капитал | 118.8 | 118.8 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 47.4 | 47.4 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,130.3 | 1,261.6 |
| Эцсийн үлдэгдэл | 1,296.4 | 1,427.7 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 387.8 | 457.0 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 387.8 | 444.1 |
| Үйл ажиллагааны ЦМГ | - | 12.9 |
| Хөрөнгө оруулалтын ЦМГ | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ | - | - |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | - | 12.9 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 12.9 |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 423.9 | 411.9 |

| | | |
|---|---|---|
| Урсгал зардал | 423.9 | 411.9 |
| Хөрөнгийн зардал | - | - |
| Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 423.9 | 424.9 |
| Улсын төсвөөс санхүүжих | 348.7 | 348.7 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 75.2 | 75.2 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 12.9 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй болно.

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн зөрчил[2] илрүүлж тус зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9 нэр төрлийн үлдэх өртгүй хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 сарын 18-ны өдрийн №271 тоот тогтоолын 7.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй болович гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*". 7.3-д *"Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 7.1, 7.2-д заасан асуудлаар саналаа бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхдээ дараах баримт материалын хамт ирүүлнэ*", 7.3.2 *“Эрх бүхий байгууллагаар хөрөнгийн үнэлгээ, 7.3.5-д "Ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцсэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт"*, 7.3.6-д *"Хөрөнгийн жагсаалт /нэр, тоо ширхэг, ашиглалтад орсон он, шинэчлэн тогтоох үнийн санал, ашиглалтын хугацааг сунгах санал”* гэсэн заалттай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 сарын 18-ны өдрийн №271 тоот тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах

2. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* 2022 онд БШУ-ны газраас тухайн байгууллагын нэмэлт дансанд 3.2 сая төгрөгийн орлогыг хөрөнгө худалдан авахад зориулан хийжээ. Тус байгууллага нь Цахим

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дэлгүүрээс тухайн хөрөнгийг худалдан авахгүйгээр цахим дэлгүүрт байршуулаагүй газраас хөрөнгийг худалдан авсан..

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Залруулга хийгдээгүй | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Алдаа илрээгүй | | | | | | | | |
| | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Алдаа илрээгүй | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй. | 1 | 3,200.0 | | | | | 1 | 3200.0 |
| Дүн | 1 | 3.200.0 | 0 | 0 | | | 1 | 3200.0 |
| Нийт дүн | 1 | 3.200.0 | | | | | 1 | 3,200.0 |